

МУИС-ИЙН СУДАЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ХУРИМТЛАЛЫГ БҮРДҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь МУИС-ийн судалгааны үйл ажиллагааг дэмжихэд шаардлагатай хуримтлалыг хэрэгжүүлж буй төслүүдээс шимтгэл тооцох замаар бүрдүүлэх, зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 “Төсөл” гэдэгт МУИС-ийн судлаач, суралцагчдын оролцон, хэрэгжүүлж буй дараах үйл ажиллагааг ойлгоно. Үүнд:
 - i) Улсын захиалгат (сэдэвт ажил, төсөл, инновацийн төсөл, зэхэц ажил);
 - ii) Олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр;
 - iii) Гадаадын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтарсан эсвэл нэг талын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр;
 - iv) МУИС-ийн дотоод төсөл;
 - v) Дотоодын үйлдвэр, аж ахуйн байгууллагатай хамтарсан эсвэл нэг талын санхүүжилттэй төсөл, гэрээт ажил.
- 1.3 Шинжлэх ухаан, технологийн сан (ШУТС) хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд, энэ журам нь ШУТС-гийн санхүүжилттэй сэдэвт ажил, төслүүдэд хамаарахгүй.

Хоёр. Судалгааны үйл ажиллагааг дэмжих хуримтлал бүрдүүлэх

- 2.1 Хуримтлалыг МУИС-ийн судалгааны мэдээллийн санд бүртгэгдсэн төслүүдээс шимтгэл тооцох замаар бүрдүүлэх бөгөөд шимтгэлийн тогтоохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 1.1.1 Төслийн нийт төсвийн 10 хувиар тооцно.
 - 1.1.2 Шимтгэлийн хувийн талаар төслийн гэрээнд тусгай заалттай бол гэрээний дагуу тооцно.
 - 1.1.3 МУИС-ийн дотоод төслүүдээс шимтгэл тооцохгүй.
- 2.2 Тухайн төслийн шимтгэлийн 50 хувийг бүрэлдэхүүн сургуульд нь шилжүүлнэ.

Гурав. Хуримтлалын хуваарилалт ба зарцуулалт

- 2.3 Зарцуулалт нь тухайн жилийн хуримтлалын 70 хувиас хэтрэхгүй байна.
- 2.4 Хуримтлалыг дараах хэлбэрээр зарцуулна.
 - 2.4.1 МУИС-ийн дотоод төслийг санхүүжүүлэх;
 - 2.4.2 Профессорын багийн судалгааны суурь зардлыг санхүүжүүлэх, дагалдагч суралцагчдад тэтгэлэг олгох;
 - 2.4.3 МУИС-ийн нэрэмжит грант, тэтгэлэгийг суралцагчдын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих урамшуулах зорилгоор олгох.
- 2.5 Тухайн жилд зарцуулах хуримтлалын төсвийг Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, захиран зарцуулна.

- 2.6 Бүрэлдэхүүн сургуульд хуваарилагдсан шимтгэлийг тухайн сургууль эрдмийн зөвлөлөөрөө хэлэлцүүлэн, зөвхөн эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааг дэмжих зориулалтаар зарцуулна.

Дөрөв. Зарцуулалтын гүйцэтгэлийн хяналт

- 2.7 Хуримтлалын зарцуулалтын тайланг Эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирал жилд 1 удаа Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлнэ.
- 2.8 Тухайн төслийн шимтгэлийг уг төслийг хэрэгжүүлж буй судлаач, судалгааны багаас сургуульд оруулсан орлогод тооцно.
- 2.9 Сургуульд оруулсан орлогыг профессорын багийн ахлагчийн хувьд үр дүнгийн гэрээний биелэлтэнд, бусад профессор, багшийн хувьд “МУИС-ийн багшийн орон тоо, ажлын үнэлгээний журам”-ын дагуу эрдэм шинжилгээний ажлын ноогдолд тус тус тооцно.